25. **Develop long-term energy solutions for urban areas.** Ulaanbaatar has growing energy and heating needs. Energy solutions that can cope with future demand should be developed now and be closely aligned with Mongolia's environmental targets. Urban redevelopment will require energy solutions for the *ger* areas, including connecting these areas to reliable and clean energy and heating sources. In this context, adding new electricity and heat-generation capacity in Ulaanbaatar is critical to meeting the established policy target in 2025. One approach would be to develop cutting-edge combined heat and power plants to optimally supply affordable electricity and heating. Distributed renewable energy systems, i.e., geothermal with solar thermal and storage solutions, should also be tested for possible deployment in areas where extending the district heating system is uneconomical.

I. Ерөнхий зүйл

1. Агаарын бохирдлыг улам бүр эрчимжиж буй үйлдвэржилтийн төлөөс хэмээн хүлээж авах нийтлэг хандлага бий. Гэтэл их хэмжээний бохирдолд удаан хугацаагаар өртсөн иргэд эрүүл мэндээрээ хохирохын зэрэгцээ ажил хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжоо алддаг нь нийгэм-эдийн засгийн асар их үр дагаврыг араасаа дагуулдаг. Эдгээр асуудлуудыг шийдвэрлэхэд бодит шинэчлэл, бодлогын алхмуудаар дэмжигдсэн, олон нийтийг хамарсан, харилцан уялдаатай үйл ажиллагааг авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай.

2. Улаанбаатар хотын агаарын бохирдол аюултай түвшинд хүрээд байна. Хөдөөгөөс хот руу чиглэсэн хүн амын шилжилт хөдөлгөөнийг зохицуулах хот төлөвлөлт байхгүй байгаа нь асуудлын гол шалтгаан юм. Үр дагавар нь эрүүл мэндийн сөрөг нөлөөллөөс нэгэнт хальж улс орны хөгжлийн томоохон сорилтыг бий болгожээ. Үүний нэг жишээ нь, 2013 онд агаарын бохирдлоос үүдэлтэй нийгмийн халамжийн зардал тухайн жилийнхээ ДНБ-ний 6.9 хувьтай тэнцсэн байна.¹

3. Нийслэлийн хүн ам 2025 онд 1.9 сая, 2050 онд 2.7 сая болж өсөх тооцоо байдаг. Шийдэмгий арга хэмжээ цаг алдалгүй авахгүй бол бохирдол болон түүнээс гарах хохирол ноцтой түвшинд хүрэх аюул нүүрлээд байна. Улаанбаатар хотын агаарыг бохирдуулж буй гол хүчин зүйлст дүн шинжилгээ хийсний үндсэн дээр агаарын бохирдлын эсрэг тэмцэх цогц шийдлийг боловсруулахтай холбогдох бодлогын зөвлөмжүүдийг энэхүү баримт бичигт толилууллаа.

II. Улаанбаатар хотын агаарын бохирдол ба бодлогын сорилт

4. Өвлийн улиралд Улаанбаатар хот дэлхийн хамгийн хүйтэн бөгөөд бохирдол ихтэй нийслэл хот болдог. Өвлийн саруудад $PM_{2.5}$ буюу нарийн ширхэглэгт тоосонцрын жилийн дундаж агууламж зөвшөөрөгдөх хэмжээнээс 40 дахин өндөр байдаг бол зарим өдрүүдэд 80 дахин өндөр байх тохиолдлууд ч гарсаар байна.² Энэ бохирдлын түвшинд хүний болон байгалийн хүчин зүйлс нөлөөлж байгаа юм. Ган, зудын давтамж нэмэгдсэн нь хөдөөгийн малчдын амьдрах орчин нөхцлийг хүндрүүлж, хот суурин газар бараадахад хүргэж байгаа бөгөөд үүний дүнд Улаанбаатар хотын хүн ам 2007 оноос хойш 30 хувиар өсөж 1.5 саяд хүрчээ. Шинээр шилжин ирэгсдийг зохистой шингээхүйц хот төлөвлөлт дутагдсанаас томоохон талбайг хамрах гэр хорооллууд үүсэн бий болсон. Өнөөдөр нийслэлийн нийт хүн амын 60 хувь буюу 800,000 хүн гэр хороололд оршин сууж байна.

¹ Дэлхийн банк. 2016. *Агаарын бохирдлын өртөг: Зайлшгүй авах арга хэмжээний эдийн засгийн үндэслэлийг нотлох нь*. Вашингтон хот.

² $PM_{2.5}$ гэдэг нь 2.5 микрометр хүртэлх диаметртэй нарийн ширхэглэгт тоосонцрыг хэлнэ.

Winning the Fight Against Air Pollution in Ulaanbaatar

— Улаанбаатар хотын агаарын бохирдлын эсрэг тэмцэлд ялах нь —

5. Гэр хороололд цэвэр бохир ус, нийтийн тээвэр, дулаан хангамж, гэрэл цахилгаан зэрэг нийтийн аж ахуйн суурь үйлчилгээ дутмаг байна. Гэр хорооллын оршин суугчид орон гэрээ халаах болон хоол хүнсээ бэлтгэх зорилгоор түүхий нүүрс (ядуу өрхүүдийн хувьд хатуу хог хаягдал) түлдэг. Энэ галлагаанаас гарч буй $PM_{2.5}$ нь өвлийн улиралд нийт нарийн ширхэглэгт тоосонцрын ялгарлын 80 хувийг бүрдүүлж байна. Үлдсэн 20 хувийг гэр хороолол дахь хуучин уурын зуухнууд, замын түгжрэл үүсгэгч тээврийн хэрэгслүүд, насжилт өндөртэй дулааны цахилгаан станцууд, шороон замаас дэгдэх тоос, нүүрсний дэгдэмхий бодис зэрэг бүрдүүлдэг. Үүний зэрэгцээ өвлийн улиралд тохиох агаарын инверцийн үзэгдэл нь (газрын гадаргууд ойр орших дулаан агаарын давхарга хүйтэн агаарын давхаргатай харших үзэгдэл) нийслэл хотын байрлах хөндийд агаарын давхаргыг тогтоож, бохирдол сарнин замхрах боломжийг хязгаарладаг байна.

6. Хүн амын эмзэг бүлгүүд агаарын бохирдлын сөрөг нөлөөнд хамгийн ихээр өртөж байна. Ядуу иргэд гол төлөв бохирдол ихтэй дүүргүүдэд ажиллаж амьдардгийн дээр шим тэжээлтэй хоол хүнс, эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чаддаггүйгээс бохирдлын нөлөөг хамгийн түрүүнд мэдэрдэг. Мөн хүүхэд нялхаст хүндээр тусч буйг ургийн өсөлт хөгжил удаашрах, хүүхэд дутуу төрөх, хатгаа, тархины хөгжлийн саатал, амьсгалын замын архаг болон цочмог өвчлөлийг үүсгэгч уушгины эмгэг зэрэгт хүүхдүүд ихээр өртөж байгаагаас харж болохоор байна. НҮБ-ийн Хүүхдийн сангаас 2018 онд хийсэн судалгаанд 2009-2011 оны өвөл нярайн эндэгдэл зуны улирлынхаас 3.5 дахин өндөр байсныг дурджээ.³ Иргэдийн эрүүл мэндийг төрсөн цагаас нь эхлэн хохироож буй агаарын бохирдлын улмаас өвчлөх, хөдөлмөрийн чадвараа алдах, эрт нас барах зэргээр хөдөлмөрийн бүтээмж буурч, иргэдийн орлого олох боломж хаагдаж байна. НҮБ-ийн Хүүхдийн сангаас хийсэн судалгаагаар агаарын бохирдлоос үүдэлтэй хүүхдийн өвчлөлд 24.8 тэрбум төгрөгийн (9.8 сая ам.доллар) нэмэлт хөрөнгийг 2017-2025 онуудад зөвхөн Улаанбаатар хотод зарцуулах шаардлага үүснэ хэмээн тогтоожээ.

7. Хот төлөвлөлт хангалтгүйгээс үүссэн нөхцөл байдлыг бодлогын тууштай бус алхмууд улам хүндрүүлсэн байх магадлалтай. Жишээлбэл, түүхий нүүрсний хэрэглээнээс үүдэлтэй агаарын бохирдлыг бууруулах бодлогын арга хэмжээнүүдийг шуурхай авч хэрэгжүүлсэн ч туршилтыг хэт жижиг хүрээнд хийсний улмаас үр дүнгүй болж, цааш нь үргэлжлүүлэх боломжгүй болсон. Цахилгаан эрчим хүчний тарифын хөнгөлөлт ч мөн цахилгаан халаагуур худалдан авалтыг дэмжих санхүүгийн механизмгүйгээр нүүрснээс татгалзах хөшүүрэг болохуйц бодлогын алхам болж чадаагүй юм. Сэргээгдэх эрчим хүчийг дэмжих урт хугацааны тарифийн асуудлаар бүрэн зөвшилцөлд хүрээгүй, мөн энэ чиглэлээр техникийн чадавх сул байгаагаас сэргээгдэх эрчим хүчийг түлхүү ашиглах боломж хязгаарлагдаж байна. Мөн агаарын бохирдлыг бууруулахад өндөр нөлөө үзүүлэх нь тогтоогдсон хэдий ч

³ НҮБ-ийн Хүүхдийн сан. 2018. *Монгол улсын агаарын бохирдлын хямрал: Хүүхдийн эрүүл мэндийг хамгаалах тухай уриалга*. Улаанбаатар.

эхний туршилтууд амжилтгүй болсноос байгальд ээлтэй сайжруулсан зуух болон цэвэр түлшний хэрэглээг тууштай дэмжээгүй юм.

8. Гэхдээ шинэ батлагдсан хуулийн хүрээнд зарим ахиц дэвшил гарсан. Агаарын тухай хуульд халаалтын зориулалттай цахилгаан эрчим хүчний хэрэглээнд иргэдэд татаас олгох, түүхий нүүрсийг оруулахыг хориглох зэрэг чухал арга хэмжээг хуульчлан заасан байна. Энэхүү хуулиар Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороог байгуулах үүргийг Ерөнхий сайдад хүлээлгэж, Цэвэр агаарын санг байгуулах эрхийг Засгийн газарт олгосон. Агаарын бохирдлын төлбөрийн тухай хуулиар агаар бохирдуулсны төлбөр төлөх тогтолцоог мөн нэвтрүүлээд байна. Эдгээр санаачилгууд нь бохирдуулагч бодисын хэмжээ хязгаарыг тогтоож, бохирдуулагчид хяналт тавьж төлбөр ногдуулдаг тогтолцоог бүрдүүлэх зорилготой байв. Гэвч бодлогын хэрэгжилт сул, бодлого тогтвортой бус, агаарын бохирдол улам нэмэгдсэн, мөн эдийн засгийн нөхцөл байдал 2015-2016 онуудад хүндэрсэн зэрэг нь агаарын бохирдлын эсрэг илүү шийдэмгий тэмцэж, бохирдлыг бууруулах хүчин чармайлтыг илүү хариуцлагатай болгохыг Засгийн газраас шаардсан олон нийтийн хөдөлгөөн өрнөхөд хүргэжээ. Үүний хариуд Засгийн газар 2016 оны 11-р сард Үндэсний хороог сэргээн байгуулсан байна. Тус хороо 2017-2025 онд хэрэгжих 9.8 их наяд төгрөг буюу 4.5 тэрбум ам.долларын төсөв бүхий Агаар болон орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг боловсруулах ажлыг удирдан чиглүүлсэн бөгөөд хөтөлбөр 2017 оны 3-р сард батлагджээ. Цогц хөтөлбөрийг боловсруулан баталсан явдал нь сайн эхлэл хэдий ч түүний хэрэгжилтийг хангахад ихээхэн хүчин чармайлт шаардлагатай байна. Өөрөөр хэлбэл, Засгийн газар улс төрийн мөчлөгөөс үл хамааран урт хугацаанд тогтвортой ажиллаж байж уг хөтөлбөр үр дүнгээ өгөх юм.

III. Бусад улс орнуудын туршлага

9. Бодлогын тодорхой алхмууд болон Засгийн газрын идэвхтэй оролцооны дүнд бохирдлын хяналт амжилттай хэрэгждэгийг олон улсын туршлага харуулж байна. Олон нийтийн мэдлэг ойлголт, иргэдийн шахалт дарамт нь засгийн газрын хариуцлагыг бэхжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэдэг. Жишээлбэл, 1970-аад онд АНУ-д агаарын бохирдлыг бууруулахад чухал нөлөө үзүүлсэн Байгаль хамгаалах алба байгуулагдаж, Цэвэр агаарын тухай хууль батлагдахад байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагууд голлох үүргийг гүйцэтгэж байв.

10. Зарим улс орнууд бохирдлыг ихээр үүсгэгч авто машины болон түлшний хэрэглээг бууруулахад чиглэсэн хөшүүрэг бүхий хууль эрх зүйн орчныг амжилттай бүрдүүлсэн байдаг. Энэхүү арга нь боломжийн өртгөөр орлуулах хувилбарт сонголт, шаардлагатай өөрчлөлтийг хүлээж авахад бэлэн олон нийтийн мэдлэг ойлголт, засгийн газрын тогтвортой бодлого, тууштай үйл ажиллагаанд тулгуурлан хэрэгжүүлсэн тохиолдолд бодитой үр дүнд хүрдэг болохыг олон улсын туршлага харуулдаг. Ирланд улсын Дублин хотод “Утаат нүүрсийг хориглох тухай хууль”-ийг 1990 онд батлан хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үр дүнд

Winning the Fight Against Air Pollution in Ulaanbaatar

— Улаанбаатар хотын агаарын бохирдлын эсрэг тэмцэлд ялах нь

нь 8,000 дутуу төрөлтөөс урьдчилан сэргийлж чадсан байна.⁴ Энэ туршлага дээрээ үндэслэн Ирландын засгийн газар “агаарын чанарыг сайжруулах бүсүүд”-д нүүрс болон зарим түлшийг хориглох тухай шийдвэрийг мөн гаргаж байв. Ингээд хоригийг орон даяар хэрэгжүүлэх тухай шийдвэрийг 2017 оны 12-р сард гаргасан бөгөөд нүүрс түгээгчдэд үлдэгдэл нөөцөө борлуулах боломжийг олгох үүднээс 2019 оноос хүчин төгөлдөр болгохоор шийдвэрлэсэн байна.

11. Агаар бохирдуулагч хорт бодисуудыг технологи ашиглан хязгаарласан тод жишээг Германы туршлагаас харж болно. Хамгийн цэвэр цахилгаан станцтай улсад тооцогддог тус улсын эрчим хүчний салбар шатдаг түлшнээс хамааралтай хэвээр байгаа ч агаарын бохирдлын эсрэг тэмцлийг тус улс түүчээлж байгаа билээ. Герман улс болон Их Британи Умард Ирландын Нэгдсэн вант улс нь түлшний хатуу хяналтын тогтолцоог 1980-аад онд нэвтрүүлсний үр дүнд (хар тугалгагүй болон хүхрийн нэн бага агууламжтай түлш) тээврийн хэрэгслээс үүдэлтэй агаарын бохирдлыг үлэмж хэмжээгээр бууруулж чадсан байна.

12. Олон нийтийн хүчтэй шахалтаар Засгийн газраас шийдэмгий авч хэрэгжүүлсэн арга хэмжээгээр тодорхойлогдох БНХАУ-ын арга барилыг харахад сургамжтай зүйл их байна. Хэрэгжихүйц, зорилтот арга хэмжээнүүдийг боловсруулан, шинжлэх ухааны үндэслэлтэй судалгаа шинжилгээнд үндэслэн бохирдлыг ойлгож, бэрхшээлийг тодруулахад хөрөнгө санхүү харамгүй зарцуулжээ. Эрх бүхий байгууллагуудын хийсэн дүн шинжилгээнд үндэслэн өртөг зардал нэлээд өндөр хэдий ч үр дүнтэй алхмуудыг тодорхойлж, үндэсний хэмжээний томоохон хөтөлбөрт тусгасан байдаг. Үүнд, нүүрсний хэрэглээнд хязгаар тогтоох, гангийн үйлдвэрлэл зэрэг үндэсний томоохон үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний хэмжээнд хяналт тавих зэрэг заалтууд тусгагдсан байна. Засгийн газрын хүчин чармайлт, манлайлал нь бодлогын хэрэгжилтэд хамгийн том түлхэц болсон байдаг. Эдгээр хүчин чармайлт оргилдоо хүрч, эхний гарсан амжилтуудаа бодит болгох, авч хэрэгжүүлсэн арга хэмжээгээ үргэлжлүүлэхэд институцийн төвшинд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2018 оны 3-р сард байгаль орчны “хүчирхэг” яамыг үүсгэн байгуулсан байна.

IV. Зөвлөмжүүд

13. Дээр дурдсан сургамж туршлагаадаас авах зүйл их бий ч хөдөөгөөс хотыг зорих хүн амын шилжилт хөдөлгөөн эрчимтэй явагдаж байгаа, тэсгим хүйтэн өвлийн улиралтай Монгол улсын хувьд тулгарч буй сорил бэрхшээл нь нэлээдгүй өвөрмөц тул тэрхүү онцлогт нийцсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай. Тэдгээр арга хэмжээнүүд нь Засгийн газрын тууштай манлайлал дор олон нийт, иргэний нийгмийн байгууллагууд,

⁴ Ирланд улсын Засгийн газар. Харилцаа холбоо, уур амьсгалын арга хэмжээ, байгаль орчны газар. Утаат нүүрсийг хориглох тухай хууль. <https://www.dccae.gov.ie/en-ie/environment/topics/air-quality/smoky-coal-ban/Pages/default.aspx> (2018 оны 9 дүгээр сард хандсан).

хувийн хэвшил, хөгжлийн түншүүд зэрэг олон оролцогчдын харилцан уялдаатай, тогтвортой хүчин чармайлтын дүнд амжилттай хэрэгжих боломжтой. 2020 он хүртэл богино хугацаанд авч хэрэгжүүлэх арга хэмжээнүүд нь агаарыг бохирдуулагч гол үүсвэрүүдийг цөөлөх, бохирдлоос үүдэж буй өвчлөлийг бууруулах зэрэгт чиглэвэл зохилтой. Харин 2030 он хүртэлх урт хугацааны арга хэмжээний хүрээнд агаарын чанарыг тогтвортой сайжруулах асуудалд анхаарах нь чухал юм. Урт болон богино хугацааны бодлогыг боловсруулах, төлөвлөх, төсөвлөх нь амар хийгдэх ажил биш ч амжилттай хэрэгжүүлсэн тохиолдолд Монгол Улсын бүтээмжийг тогтвортой өсгөж, ирээдүйн хөгжил цэцэглэлтийг тодорхойлох эдийн засгийн идэвхитэй хот суурин газруудын үндэс суурийг тавих юм. Монгол Улсын Засгийн газар олон тооны зөв зүйтэй алхмыг авч хэрэгжүүлж буйн тод жишээ нь Улаанбаатар хотод хэрэглэгдэх түлшний чанарыг дээшлүүлэх, агаарын чанарыг сайжруулахтай холбогдох хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгох тал дээр АХБ-наас өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд өндөр ач холбогдол өгч байгаа явдал юм.⁵ Түүнчлэн, асуудлыг шийдвэрлэхэд шаардлагатай дэмжлэг туслалцааг бусад олон хөгжлийн түншүүд үзүүлсээр байна. Гаргасан амжилтаа ахиулж, илүү ихийг хийх боломж байгааг харгалзан дараах зөвлөмжүүдийг өгч байна. Үүнд:

а. Богино хугацааны бодлогын арга хэмжээнүүд

14. Бохирдлыг бууруулахад чиглэсэн бодлогын арга хэмжээнд хяналт тавих оролцогч талуудын санаачлагыг бий болгох. Агаарын бохирдлыг бууруулах үндэсний хороо нь агаарын чанарт эерэг нөлөө үзүүлэх гол арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх эрх мэдэлтэй байх хэрэгтэй. Учир нь агаарын бохирдлыг бууруулахад олон жилийн туршид тогтвортой, тууштай, харилцан уялдаатай ажиллах шаардлагатай байдаг тул улс төрийн түвшинд талууд бүрэн зөвшилцөлд хүрэх нь нэн чухал юм. Ингэж чадвал улс төрийн ямар хүчин эрх барьж байгаагаас үл хамааран агаарын бохирдолтой тогтвортой бөгөөд тууштай тэмцэх баталгаа үүснэ. Үүний тулд Засгийн газрын зүгээс Үндэсний хорооны шийдвэрийн хэрэгжилтийг хянах, уялдааг хангах, зохих хяналтыг тавих чиг үүрэг бүхий улс төрөөс хараат бус ажлын албыг байгуулах хэрэгтэй гэж үзэж байна. Түүнчлэн, бодлогын залгамж чанарыг үргэлжлүүлэх үүднээс тухайн ажлын алба нь агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүдийг дэс дараалан бүртгэж, баримтжуулан хадгалах үүрэгтэй байвал зохино. Тус ажлын албанд бодлого тодорхойлогчид, иргэний нийгмийн байгууллагууд, сэтгүүлчид, хувийн хэвшлийн төлөөлөл зэрэг талуудыг байлцуулснаар бүх талын оролцоог ханган, дэмжлэгийг авч, Засгийн газрын хүрээнд хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх боломжтой болох юм.

⁵ АХБ. 2018. *Улаанбаатар хотын агаарын чанарыг сайжруулах хөтөлбөр*. Манила хот.

Winning the Fight Against Air Pollution in Ulaanbaatar

—Улаанбаатар хотын агаарын бохирдлын эсрэг тэмцэлд ялах нь—

15. Агаарын бохирдлын талаарх мэдээлэл сурталчилгааг эрчимжүүлснээр олон нийтийн ойлголтыг нэмэгдүүлэх. Агаарын бохирдлын бодит түвшин болон эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөөллийн талаарх үнэн зөв мэдээллийг Улаанбаатар хотын иргэдэд тогтмол өгч байх хэрэгтэй. Баталгаат эх сурвалжуудаар дамжуулан мэдээллийг илүү өргөн хүрээнд түгээхэд анхаарах нь чухал. Энэ ажлын хүрээнд хотын тодорхой байршлуудад агаарын чанар ямар байгаа талаар тогтмол сануулга анхааруулга цацах, мөн эмнэлэг, сургууль зэрэг олон нийтийн газруудын агаарын бохирдлын хэмжээг тогтмол хянах зэрэг ажлуудыг хийж болох юм. Агаарын бохирдлоос үүдэх хор хохирлыг сааруулах үр дүнтэй арга замыг иргэдэд мэдээлэх, жишээ нь, амны маскны ач холбогдол, маскны сонголт зэрэг асуудлаар иргэдийн мэдлэг ойлголтыг дээшлүүлэх кампанит ажил хийх хэрэгтэй. Мөн дотор болон гадна орчны агаарын бохирдлын уялдаа холбооны талаар иргэдийн мэдлэг ойлголтыг бэхжүүлэх нь кампанит ажлын бас нэгэн чухал чиглэл байж болох юм.

16. Агаарын бохирдлын үзүүлж буй нөлөөлөлд дүн шинжилгээ хийх аргачлалыг сайжруулах, нөлөөг бууруулах, түүнээс зайлсхийх үр дүнтэй арга хэрэгслийг тодорхойлох. Монгол улсад агаарын бохирдлын эсрэг хэрэгжүүлж болох төрөл бүрийн бодлогууд хэр үр дүнтэй байх талаар бодлого тодорхойлогчид болон бусад оролцогч талууд нэгдмэл ойлголтгүй байна. Боломжит бодлогын арга хэмжээнүүдийг дүн шинжилгээнд тулгуурлан бодитойгоор үнэлснээр шийдвэр гаргагчид өртөг зардлын хувьд хамгийн үр ашигтай шийдлүүдийг тодорхойлж, холбогдох төсвийн хуваарилалтыг хийх боломжтой болох юм. Энэ нь хууль тогтоогчдод дөхөм болоод зогсохгүй бодлого тодорхойлогчдоос хариуцлага нэхэх боломжийг олон нийтэд олгоно. Тиймээс агаарын чанарын удирдлагын асуудлаар судалгаа шинжилгээний хөтөлбөр боловсруулах зэргээр агаарын бохирдлын нөлөөллийн судалгааг өргөжүүлэхэд анхаарах нь чухал байна.

17. Эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаанд стандарт тогтоож, гэрчилгээжүүлэх. Агаарын бохирдлын сөрөг нөлөөг бууруулах арга хэрэгслийн талаарх олон нийтийн мэдлэг, ойлголт сул байна. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын оршин суугчид сөрөг нөлөөг бууруулах арга хэрэгслийг хэрэгжүүлдэггүй, аль эсвэл буруу хэрэглэдэг гэсэн үг юм. Амны маск, бохирдлыг хянах төхөөрөмж, агаар цэвэршүүлэгч зэрэг хамгааллын арга хэрэгслүүдийн талаар суурь стандартуудыг олон улсын хэм хэмжээнд тулгуурлан боловсруулах хэрэгтэй. Мөн түүнчлэн, бохирдлын нөлөөнөөс хамгаалах бараа бүтээгдэхүүн холбогдох норм стандартыг хангаж байгаа эсэхийг хэрэглэгчдэд тодорхой харуулах гэрчилгээжүүлэлтийн системийг нэвтрүүлэх асуудлыг судалж үзэх нь чухал.

18. Түүхий нүүрс болон хатуу хог хаягдал шатаах үйл ажиллагааг хязгаарлах. Байгальд ээлтэй түлшний хэрэглээг тогтвортой түвшинд хөхиүлэн дэмжих хүчин чармайлтыг бодлогын тэргүүлэх чиглэл болгох нь чухал байна. 2019 оны 5-р сараас Улаанбаатар хотод түүхий нүүрс түлэхийг хориглох шийдвэр гаргасан нь сайшаалтай эхлэл бөгөөд цаашлаад цэвэр нүүрсний худалдан авалт, түгээлтийн механизмыг бий болгох замаар цэвэр нүүрсний зах зээлд хувийн хэвшлийг татан оролцуулах хэрэгтэй. Энэ

нь эргээд хөнгөлөлт татаас олгох шаардлагыг бууруулж, хангалттай хэмжээний түлшийг агуулах болон түгээх сувгуудыг үүсгэн бий болгох юм. Үүний зэрэгцээ, сайжруулсан болон цахилгаан зуухыг нэвтрүүлэх ажлыг зэрэг явуулснаар үр нөлөөг хамгийн өндөр түвшинд хүргэх боломж бүрдэнэ.

19. Хорт бодис ялгаруулах хэмжээгээр нь бохирдуулагч бараа бүтээгдэхүүнийг ангилах. Агаарын бохирдлыг бууруулж, гаргасан амжилтаа урт хугацаанд хадгалахад зан үйлийн өөрчлөлт зайлшгүй шаардлагатай бөгөөд үүний тулд цэвэр түлш, аль эсвэл ялгаруулалт багатай зуухны хэрэглээг дэмжин хөшүүрэгдэх өөрчлөлтийг хийх хэрэгтэй. Үүний тулд Засгийн газраас бохирдлын эх үүсвэрүүд (зуух, түлш г.м.)-ийг ялгаруулалтын түвшнээр нь ангилах зохицуулалтыг нэвтрүүлвэл зохино. Энэ нь улмаар тээврийн салбарт чанар муутай түлш нийлүүлэгч илүү өндөр татвар төлдөг, цэвэр түлш нийлүүлэгчид хөнгөлөлт эдэлдэг гэх мэт практик үр дагавар бүхий алхмуудын урьтал болох юм. Бизнесийн үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл, агаар бохирдуулагч бодисын зөвшөөрөгдөх хэмжээ, “бохирдуулагч нь төлөх” зарчим зэрэгтэй холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллах нь төрийн хяналтыг хэрэгжүүлэгч байгууллагуудын хувьд чухал.

20. Шинэ технологи нэвтрүүлэлтийг дэмжих. Шинэ технологи, шилдэг стратегийн бүрдэл нь агаарын бохирдлыг бууруулах урт хугацааны шийдлүүдийг тодорхойлоход дэмжлэг болно. Эдгээрт төлбөрийн чадварт нийцсэн орон сууцны хангамжийг сайжруулах, цахилгаан халаалтын дэд бүтцийг хүртээмжтэй болгох, цэвэр нүүрс, цахилгаан зуух гэх мэт бохирдлыг бууруулах арга шийдлүүдийг дурьдаж болно. Эдгээр шийдлүүдийг урт хугацааны бодлогод тусгахаас гадна технологи, стратегийг нь одоо нэвтрүүлж, туршиж үзэх нь туйлын чухал. Ингэснээр хот төлөвлөлт, байгуулалтын явцад орон сууц, эрчим хүчний шийдлүүдийг өргөн хүрээнд хэрэгжүүлэх боломж бүрдэх үед олон төрлийн хувилбаруудын аль нь илүү үр ашигтай болохыг урьдчилан тодорхойлж, нотолсон байх юм. Ийм санал санаачлага, технологиуд санхүүжилт шаардах тул Засгийн газар, хувийн хэвшил, хөгжлийн түншүүд эхний ээлжинд шаардлагатай хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх, ирээдүйд өргөжүүлэн хэрэгжүүлэх үндэс суурийг тавих тал дээр хамтран ажиллах нь чухал юм.

b. Урт хугацааны бодлогын арга хэмжээнүүд

21. Хот суурин газрыг дахин төлөвлөж, хот байгуулалтыг байгаль орчны зорилтуудтай уялдуулан хэрэгжүүлэх. Орчны бохирдлыг бууруулах тогтвортой шийдлүүд нь хот суурин газрыг дахин төлөвлөхийг шаардах бөгөөд үүний дүнд иргэд байгальд ээлтэй цэвэр цахилгаан, дулаан, ариутгах татуурга бүхий чанартай орон байранд орох боломжтой болох юм. Улаанбаатар хотод хэрэгжих төсөл хөтөлбөрүүдийг өнөөгийн дэд төвүүдээр хязгаарлахгүйгээр өргөжүүлэн тэлж, гэр хорооллыг нийтийн аж ахуйн суурь үйлчилгээнд өргөнөөр хамруулахад анхаарах нь чухал байна. Агаарын бохирдол төдийгүй хөрс, усны

Winning the Fight Against Air Pollution in Ulaanbaatar

—Улаанбаатар хотын агаарын бохирдлын эсрэг тэмцэлд ялах нь—

бохирдол зэрэг орчны бохирдлын хүчин зүйлсийг хот байгуулалт, төлөвлөлтийн түлхүүр асуудал болгон авч үзэх нь чухал.

22. Хөдөө орон нутагт амьдрах боломжийг дээшлүүлж, хүн амын шилжилт хөдөлгөөнийг бууруулах. Хотжилттой холбоотой үүсэн бий болж буй дарамтыг бууруулах хамгийн найдвартай арга бол хотод байгаа эдийн засгийн боломж бололцоог хөдөө орон нутагт бүрдүүлэх явдал юм. Үүний тулд хөдөөгийн хөгжлийн бодлого төлөвлөлтийг үндэсний хөгжлийн стратегитай нийцүүлэн боловсруулах, ингэхдээ ажлын байр, эдийн засгийн өсөлт бий болгох тухайн орон нутгийн харьцангуй давуу талыг харгалзах нь чухал. Энэ арга шийдэл нь хэдийгээр илүү ярвигтай, амаргүй боловч шилжилт хөдөлгөөнийг шууд хязгаарлах арга замаас илүү үр дүнтэй хэмээн үзэж байна. Иргэд эдийн засгийн шалтгаанаар шилжин суурьшиж буй нөхцөлд шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах шийдвэрийг хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хяналт тавихад хүндрэлтэй юм.

23. Институцийн чадавхийг бэхжүүлэх. Төр захиргааны бүхий л түвшинд хэрэгжилтийг хангах чадавхи бэхжиж гэмээнэ агаарын бохирдлыг тогтвортой бууруулах зорилт биелэх боломж бүрдэнэ. Түүнчлэн, өгөгдөл мэдээллийг үр дүнтэй цуглуулж, дүн шинжилгээ хийх чадавхийг бэхжүүлснээр бохирдлыг бууруулах хүчин чармайлтыг тогтвортой үргэлжлүүлэх бодлого, зохицуулалтыг шинээр боловсруулах боломжтой болох юм. Сургалт явуулах, чадавхи бэхжүүлэх, илүү сайн тоног төхөөрөмж худалдан авах, цахим мэдээллийн удирдлагын системийг бүрдүүлж, ажиллуулахад шаардагдах технологийг нэвтрүүлэх зэрэг ажлуудыг цогцоор хийснээр хяналтыг сайжруулна.

24. Тогтвортой тээврийн салбарын төлөвлөлтийг хийх. Тээврийн салбар нь Улаанбаатар хотын агаарын бохирдлын гол эх үүсвэр биш хэдий ч хотыг дахин төлөвлөх, хотын эдийн засгийн эрчим нэмэгдэх хэрээр тээврийн салбарын эрэлт хэрэгцээ өсөх нь тодорхой. Тиймээс агаарын бохирдлыг улам дордуулахгүйгээр өсөн нэмэгдэх эрэлтийг бүрэн хангахуйц тээврийн системийг хөгжүүлэх нь чухал. Энэ чиглэлээр хэрэгжих бодлогын хүрээнд хөдөлгүүрийн хорт хийн ялгарлын стандартад нийцсэн цэвэр түлшний хэрэглээ, хувийн автомашины тоог бууруулах нийтийн тээврийн оновчтой систем, автомашины дундын хэрэглээ, хөдөлгөөн хязгаарлах бүсүүд зэрэг олон асуудлыг авч үзэх боломжтой.

25. Хот суурин газрын эрчим хүчний хангамжийн урт хугацааны шийдлүүдийг хөгжүүлэх. Улаанбаатар хотын эрчим хүч, дулааны хэрэгцээ улам бүр өсөж байна. Өсөн нэмэгдэх хэрэгцээг хангах эрчим хүчний хангамжийн шийдлүүдийг урьдчилан боловсруулах, байгаль орчны зорилтуудтай нягт уялдуулах нь туйлын чухал. Хотын дахин төлөвлөлтийн хүрээнд гэр хорооллын эрчим хүчний хангамжийн шийдлүүд, үүний дотор гэр хорооллыг найдвартай бөгөөд цэвэр эрчим хүч болон дулааны эх үүсвэрт холбох асуудлыг шийдвэрлэх шаардлагатай байна. Энэ утгаар цахилгаан эрчим хүчний болон дулааны шинэ эх үүсвэрүүдийг ашиглалтад оруулах нь 2025 оны бодлогын зорилтуудын хэрэгжилтийг хангахад чухал үүргийг гүйцэтгэх болно. Цахилгаан дулааны хамгийн сүүлийн үеийн

Observations and Suggestions

Ажиглалт ба санал

технологи бүхий хосолмол үүсгүүрүүдийг байгуулж, төлбөрийн чадварт нийцэх цахилгаан эрчим хүч, дулаан нийлүүлэх хувилбаруудыг судлан үзэх нь зүйтэй. Төвлөрсөн дулаан хангамжид холбох нь эдийн засгийн үр ашиггүй хэмээн үзэж буй байршлуудад сэргээгдэх эрчим хүчний төвлөрсөн бус хангамж (жишээ нь газрын гүний дулаан, нарны эрчим хүч, хураагуурын хосолмол шийдлүүд) -ийг туршиж, ирээдүйд нэвтрүүлэх боломжийг судлах нь зүйтэй хэмээн үзэж байна.

Winning the Fight Against Air Pollution in Ulaanbaatar

This policy note draws on successful experiences of other countries to offer practical recommendations for improving the air quality in Ulaanbaatar and other cities in Mongolia. Urban air pollution is an urgent and serious public health and environmental challenge with enormous socioeconomic costs for Ulaanbaatar. The recommendations provided here acknowledge the existing policy and encourages its translation to an institutionalized framework for sustainable solutions. Designing, planning, and budgeting short- and long-term policies is challenging, but success will result to a significant and sustained boost in productivity and lay the foundations for dynamic urban centers to drive the economic growth of Ulaanbaatar and Mongolia.

Улаанбаатар хотын агаарын бохирдлын эсрэг тэмцэлд ялах нь

Энэхүү баримт бичиг нь агаарын бохирдлыг амжилттай бууруулсан улс орнуудын туршлага, сургамж дээр үндэслэн Улаанбаатар болон бусад хотуудын агаарын чанарыг сайжруулахад бодитоор хэрэгжүүлэх боломжтой зөвлөмжүүдийг санал болгоно. Агаарын бохирдол нь Улаанбаатар хотын хувьд нийгэм-эдийн засгийн асар өндөр өртөгтэй, эрүүл мэнд, байгаль орчны тулгамдсан асуудал болоод байна. Энд санал болгосон зөвлөмжүүд нь одоо авч хэрэгжүүлж буй бодлогын алхмуудыг хүлээн зөвшөөрч, тогтвортой шийдлүүд бүхий институцийн орчинг бий болгохыг дэмжинэ. Урт болон богино хугацааны бодлогыг боловсруулах, төлөвлөх, төсөвлөх нь амар хийгдэх ажил биш ч амжилттай хэрэгжүүлсэн тохиолдолд Монгол Улсын, тэр дундаа Улаанбаатар хотын бүтээмжийг тогтвортой өсгөж, ирээдүйн хөгжил цэцэглэлтийг тодорхойлох эдийн засгийн идэвхитэй хот суурин газруудын үндэс суурийг тавих юм.

About the Asian Development Bank

ADB is committed to achieving a prosperous, inclusive, resilient, and sustainable Asia and the Pacific, while sustaining its efforts to eradicate extreme poverty. Established in 1966, it is owned by 67 members—48 from the region. Its main instruments for helping its developing member countries are policy dialogue, loans, equity investments, guarantees, grants, and technical assistance.

Азийн хөгжлийн банкны тухай

АХБ нь Ази, Номхон далайн бүс нутагт нэн ядуурлыг арилгах хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийн зэрэгцээ цэцэглэн хөгжсөн, хүртээмжтэй, тогтвортой, сөрөг нөлөөнд тэсвэртэй бүс нутгийг цогцлоохын төлөө тууштай ажилладаг. Анх 1966 онд байгуулагдсан тус банкны нийт 67 гишүүн орны 48 нь тухайн бүс нутагт оршдог. АХБ нь бодлогын хэлэлцүүлэг, зээл, өөрийн хөрөнгийн санхүүжилт, батлан даалт, буцалтгүй тусламж болон техникийн туслалцаа зэрэг олон төрлийн арга хэрэгслээр дамжуулан хөгжиж буй гишүүн орнууддаа дэмжлэг үзүүлж байна.



ASIAN DEVELOPMENT BANK

6 ADB Avenue, Mandaluyong City

1550 Metro Manila, Philippines

www.adb.org

Азийн хөгжлийн банк

АХБ-ны өргөн чөлөө-6, Мандалуён хот

Метро Манила 1550, Филиппин Улс

www.adb.org